


БАТЛАВ.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА




Ж.ЦОЛМОН

ОСЛЫН ГАЗРЫН НОТЛОХ БАРИМТЫГ ФОТО ЗУРГААР
БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Баримт бичгийн код	АХОЗШША - 25-09		
Баталсан огноо:	2025 он- 11 сар- 20 өдөр		
Хянасан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	Х. Нарангучуу	2025.11.19	
Боловсруулсан:	Албан тушаал, нэр	Огноо	Гарын үсэг
	Н. Гэрэнтуул	2025.11.19	

АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБА
 АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ ГАРГАХ, ҮНЭЛЖ ДҮГНЭХ ЖУРАМ

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлтийн дугаар	Өөрчлөлтийн товч тайлбар	Өөрчлөлт оруулах хэсэг	Өөрчлөлт хийсэн ажилтны нэр, албан тушаал	Огноо	Гарын үсэг
1	Хууль, дүрэм	Бүрэг	м/м	2025. 11.20	

Түгээлтийн жагсаалт

№	Баримт бичиг	Хэнд (түгээх нэгж/байгууллага)
1	Мурал	м/м
2		
3		

ОСЛЫН ГАЗРЫН НОТЛОХ БАРИМТЫГ ФОТО ЗУРГААР БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмыг агаарын хөлгийн осол, ноцтой зөрчил гарсан үед ослын газар дээрх байдал, нотлох баримтыг баталгаажуулан хадгалах зорилгоор агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд оролцож буй шинжлэн шалгагчид дагаж мөрдөнө.

Хоёр. Нийтлэг үндэслэл

2.1. Ослын газарт фото зураг авах нь фото зургийн системтэй баримт бүрдүүлэхэд оршино. Гал унтраах, аврах, үлдэгдлийг илрүүлэх ажиллагааны үед өөрчлөгдөх юм уу устах боломжтой эд мөрийн баримтуудыг хадгалж үлдэх зорилготой.

2.2. Ослыг шинжлэн шалгах ажиллагааны үед фото зураг авах нь эд мөрийн баримтыг бүртгэх үндсэн шаардлага юм. Сайн фото зураг нь эд мөрийн баримтыг үр ашигтайгаар баримтжуулах, шинжлэн шалгасан тайлан гаргахад дэмжлэг үзүүлэх, ослын газрын нөхцөл байдлыг илрүүлэхэд тустай.

Гурав. Ослын газрыг фото зургаар баримтжуулах

3.1. Ослын байрлал, үлдэгдэл түүний нөхцөлийг бүрэн харуулсан фото зургийг нэн даруй авч эхлэх шаардлагатай. Уг ажиллагааг шинжлэн шалгах ажиллагаанд оролцож буй шинжлэн шалгагчид, ахлах шинжлэн шалгагчийн томилсон этгээд хийж гүйцэтгэнэ.

3.2. Ослын талаар системтэй фото зургийн баримт бүрдүүлэхийн тулд шаардлагатай бол, хойшлуулалгүйгээр агаараас гэрэл зураг авах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Ослын газрын ерөнхий зургийг аль болох олон удаа авна.

3.3. нотлох баримтын фото зурагт амархан устаж алга болдог эд мөрийн баримтаас эхлээд устдаггүй эд мөрийн баримт бүгд орно.

3.4. Ослын газарт янз бүрийн шалтгаанаар ослын эд мөрийн баримтууд арилж бүдгэрэх болон устаж алга болдог. Үүнд:

- Цаг агаарын болон байгаль орчны нөлөөллөөр,
- Төрөл бүрийн ажиллагаанд оролцож буй хүмүүс ослын газар дээр гарсан мөрийг санамсаргүй арилгах, эд ангийн байрлалыг өөрчлөх, бүхээг доторх унтраалга, залгууруудыг хөдөлгөх,
- Гэрчүүд цаг хугацааны явцад ой санамжаа алдах, мартагч гэх мэт. Иймд ослын газрын зургийг баталгаажуулан авч үлдэх болон шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд ослын газарт аль болох түргэн хүрэлцэн очиж фото зураг, болон видео бичлэгийг нэн даруй хийх шаардлагатай.

3.5. Шинжлэн шалгах ажиллагааны эхний үе шатанд нөхцөл байдал голдуу эмх журамгүй, замбараагүй, үйл ажиллагааны өрнөл түргэн, эд мөрийн баримтууд устаж алга болох нөхцөл, магадлал өндөр байдаг.

3.6. Ослын газар дээрх бүх үйл ажиллагаа ба олж илрүүлсэн зүйлүүдийг нэг бүрчлэн зургийг нь авч, холбогдох хүснэгтэн маягтын дагуу зураг бүрийг дугаарлан тэмдэглэн бүртгэл хөтлөх ёстой.

3.7. Ослын газрын фото зураг нь эд мөрийн баримт болох бүх зүйлсийн тодорхойлолт ба байрлалыг нарийвчлалтай бөгөөд системтэйгээр харуулсан мэдээллийг агуулах ёстой.

Дөрөв. Фото зураг ба видео бичлэг авах

4.1. Ослын газар шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй багийн ахлах шинжлэн шалгагч нь тухайн осол, зөрчилтэй холбоотой эд мөрийн баримт, газар орны байрлал, цаг агаарын байдал зэрэг бүх л нөхцөлийг харуулсан нотлох баримтуудыг баталгаажуулах зорилгоор фото зураг, видео бичлэг хийх мэргэжлийн хүнийг томилно.

4.2. Ахлах шинжлэн шалгагчийн томилсон этгээд нь ослын газар нэн даруй очиж фото, зураг авах болон видео бичлэг хийх ба авсан зураг, бичлэг бүрийг дугаарлан нэрлэж тэмдэглэн, тайлбар хийн тусгай маягтын дагуу хүснэгт бөглөнө. Хүснэгтийг хавсралт №1-д үзүүлэв.

4.3. Ослын газрын нөхцөл байдлын зураг авах видео бичлэг хийх, баталгаажуулах ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар"-ын 5.8 бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

4.4. Ослын газрын нөхцөл байдлын зургийг бүрэн авсны дараа тухайн зураг болон бичлэгийг мэргэжлийн түвшинд боловсруулж цаасан дээр буулгана.

4.2. Ослын газрын зураг авах ерөнхий төлөвлөгөөг бүрдүүлэх дараах зүйлүүдийг оролцуулан ослын газрын идэвхтэй байдлын фото зургаар яаралтай баталгаажуулж авна. Үүнд:

- хэрэв боломжтой бол агаарын хөлгийн ойртож буй болон бууж байгаа дүрсийг видео камераар авна.
- Ослын газар явагдаж байгаа аврах юм уу гал унтраах ажиллагаа
- Цаг агаар
- Ослын газар зайнаас
- Ослын газар ойрхноос
- Галын хэмжээ ба байрлал
- Ослын үлдэгдлийн шилжүүлэн байрлуулалт юм уу зөөлт
- Зорчигчийн байрлал, байрлалын өөрчлөлт юм уу хөдөлгөөн

4.4. Дараах зүйлүүдийг оролцуулан ослын газрын идэвхгүй байдлын фото зургийг авна. Үүнд:

- Газрын байдал
- Ослын замын дагуух байдал
- Ослын замын дээд талаас харагдах байдал
- Ослын замын доод талаас харагдах байдал

- План зураг (Ослын замтай перпендикуляр)
- Агаарын зураг
- Тодорхой зүйлүүд
- Налуу (өргөн, урт, зузаан)
- Бүх оролцсон зүйлүүд (ачаа)
- Навч ургамал
- Хяналтын төхөөрөмжүүд ба холбоосууд
- Сэнс, дугуй, араа
- Хөдөлгүүр ба бусад салгасан зүйлүүд
- Бутарсан хэсгүүд
- Галын гэмтэл
- Удирдлагын самбар
- Гэрлийн шил ба утас
- Агаарын хөлгийн гадна тал
- Агаарын хөлгийн дотор тал (шаардлагатай хэмжээгээр)
- Аливаа цохигдсон объектууд

4.5. Харьцуулах зорилгоор аливаа төстэй агаарын хөлгийн зургийг авч болно. Гэрлийн нөхцөл ба шаралтын түвшин шаардлагатай хэмжээнд хүрэхгүй байна гэж үзсэн үед үргэлж нэмэлт зураг авч байх ёстой. Зөвхөн хамгийн сайн зургууд нь хэвлэгдэх учраас хүссэн зургаа авсан гэдгээ баталгаажуулахын тулд аль болохоор олон зураг авах шаардлагатай. Үүний жишээ бол аливаа зүйлийн загвар юм уу хуулбар юм. Зарим тохиолдолд шинжилгээ ба тайланд харьцуулах зорилгоор яг ижилхэн боловч гэмтээгүй эд анги юм уу төхөөрөмжийн зургийг авах нь ашигтай байж болно.

4.6. Хууль сахиулах байгууллагуудыг өөрсдийн авсан фото зургийн баримт, ялангуяа аврах ба гал унтраах ажиллагааны зургийн хуулбараар хангах ёстой.

4.7. Үхлийн шалтгааныг тогтоох мэргэжилтнүүд, хэвлэл мэдээлэл, гэрчүүд зэрэг осол болсны дараа аливаа зүйлийг хөдөлгөхөөс өмнө фото зураг авсан байж болох хүмүүстэй холбоо барина.

4.8. Осол агаарт болсон бол осолд орж байгаа агаарын хөлгийн дүрс бичлэгийг авсан байж болох НХА-ны цамхгийн удирдагчтай холбоо барина.

4.8. Хальс нь хувь хүнийх бол өмчлөгчид нь хальс угаах юм уу шинээр авч өгөх зардлыг нөхөн олгоно. Хэвлэсэн зургийг өмчлөгчид удаалгүйгээр буцаан өгнө.

4.9. Агаарын үзүүлэлт, тоглолт хийж байгаа нөхцөлд олон тооны үзэгчид ба хэвлэлийнхэн ослын өмнө, дунд, дараа нь агаарын хөлгийн гэрэл зураг ба дүрс бичлэг хийсэн байх магадлалтай. Та дүрс юм уу аудио бичлэгтэй аливаа хүнтэй холбоо тогтоохын тулд радио, телевиз, сонин хэвлэлийг ашиглаж болно.

4.10. Ослын ерөнхий дүр зургийг баримтжуулахын тулд дэс дараалал бүхий аргыг хэрэглэ. Ослын үлдэгдлийн гэрэл зургийг дор хаяж 4 зүг (болж өгвөл 8 зовхисоос)-ээс авна. Хэрвээ ослын үлдэгдэл хэт том талбай дээгүүр тарсан бол 1 төгсгөлөөс нь эхэлж ослын үлдэгдлийн тархалтын шугамын дагуу давхардсан цуврал гэрэл зургийг авна.

4.11. Ослын үлдэгдлийн томоохон хэсгүүд тэр дундаа далавч, хөдөлгүүр, сүүл, сэнсийг баримтжуулахын тулд гэрэл зургийн аппарат хэрэглэнэ.

4.12. Өмчид учруулсан томоохон гэмтлийг харуулсан гэрэл зургийг авна. Ослын үлдэгдлийг холдуулах, онгойлгох, зүсэх, тэр дундаа аливаа эд ангийг задлах ажиллагааг харуулсан гэрэл зургийг авна. Эдгээр зургууд нь шинжлэн шалгах ажиллагааны явцад ослын үлдэгдэлд орсон аливаа өөрчлөлтийг баримтжуулахад тустай.

4.13. Сэргээн босгосон ослын үлдэгдлийн зургийг авна.

4.14. Гүйлтийн зам дээрх гулгалтын ул мөр юм уу газар дээр гарсан 40 футээс урт бусад ул мөрүүдийн зургийг авахдаа тухайн мөрний дагуу тогтмол зайтайгаар хэд хэдэн зураг авах шаардлагатай байж болно. Гэрэл зургийн үргэлжилсэн байдлыг хангахын тулд зураг болгон нь давхацсан дүрс ба нийтлэг харьцуулах объектыг харуулсан байх ёстой. Мөр ба гулгалтын онцлог нь ослын явцыг сэргээхэд чухал байдаг учраас тэдгээрийн гэрэл зургийг сайн авах тал дээр анхаарах шаардлагатай. Мөр ба ховил нь голдуу хөдөлгөөний чиглэлийн дагуу зургийг нь авахад илүү сайн гардаг. Сэжигтэй бүс юм уу аливаа чухал эд мөрийн баримтын зургийг ойроос юм уу томруулж авна.

4.15. Зурган дээр туузан метр, шугам юм уу мэдэгдэж байгаа хэмжээтэй бусад зүйлүүд зэрэг хэмжээг харьцуулах боломжтой тодорхой зүйлийг оруулах нь чухал юм.

4.16. Ойрын зураг авахын тулд эхлээд холоос зураг авч, дараа нь дунд зэргийн зайнаас зураг аваад дараа нь ойроос авах нь зүйтэй. Эхний 2 зураг нь харж байгаа хүнд ойроос авсан зургийн харааны харьцуулалт хийхэд тусалдаг. Боломжтой ба тохиромжтой үед аливаа гэрчийн харсан ослын дүр зураг ба хэсгийн зургийг авах ёстой.

4.17. Эдгээр зургийг авсан газруудын товч бүртгэлийг хөтөлнө. Гэрэл зураг авах ажиллагаагаа шинжлэн шалгагчдын багийн бусад гишүүд ялангуяа гэрчүүдтэй ажиллаж байгаа шинжлэн шалгагчтай харилцан зохицуулах ёстой. Ямар нэг шалтгаанаар тайланд оруулах боломжгүй аливаа чухал бичиг баримтын зургийг шаардлагатай түвшинд авах ёстой. Фото зургийг баримтжуулах хүснэгтийг хавсралт №1-т үзүүлэв.

4.18. Ослын тайланг дагалдах фото зургийн баримтын сэдэв ба бүрдэл хэсгийн стандарт нь дараах байдалтай байна.

- Ослын газар тэр дундаа газар дээр гарсан ул мөр ба саад тотгорууд
- Хоорондоо 90 хэмийн зайтайгаар 4 зүгээс авсан үндсэн ослын үлдэгдэл
- Ойртож очих хэсэг
- Эргэн тойрны газрын байдал ба боломжтой бол агаарын зураг
- Агаарын хөлгийн чухал төхөөрөмж, хянах хэрэгсэл, сэлгүүрийн байрлал, хяналтын гадаргуугийн байрлал, аэродинамик гадаргуу, хийц зэргийн ойроос авсан зураг
- Ач холбогдолтой хугарал юм уу эвдрэлийн ойроос авсан зураг
- Төхөөрөмж юм уу эд ангиудыг үргэлжлүүлэн шалгах зорилгоор зөөхөөс өмнөх олдсон байдлаар

- Чухал мэдээлэл өөр замаар олдох боломжгүй үед хүний биеийн үлдэгдэл
- Аливаа төрлийн амархан устдаг эд мөрийн баримт

4.19. Зураг авсан өдөр цаг, сэдвийг харуулсан ослын гэрэл зургийн бүртгэлийг хадгалах ёстой. Сэдэв, өдөр, зурагчин, камерын тохируулгын талаар тэмдэглэл хөтөлнө. Шаардлагатай үед гэрэл зураг юм уу дүрс бичлэг хийсэн газрын байрлалын талаар бүртгэл хөтөлнө.

4.20. Ороодог хальс болгоныг түүний дугаар, осол, өдөр, зурагчнаар нь танина.

Тайлбар: Та аппаратынхаа хальсны хурдыг буруу тохируулснаа мэдвэл тохируулгыг өөрчлөлгүйгээр үргэлжлүүлэн зураг авч боловсруулах лабораторид мэдэгдсэнээр зураг угаах ажиллагааг тохируулан өөрчилнө.

4.21. Шинжлэн шалгах ажиллагааны гэрэл зураг авах аргууд

- Аль болохоор олон зураг авна.
- Хальсыг бүхэлд нь боловсруулна.
- Бүх ороомгийг угаана.
- Тайланд оруулах шаардлагатай зургуудыг л хэвлэнэ.

4.22. Дүрс бичлэг нь ослын газар, амархан устдаг эд мөрийн баримт, ослын газар дээрх ажиллагааны эвдрээгүй, бодит цагийн, орчны дүрсийг бичихэд хамгийн тохиромжтой байдаг. Эд мөрийн баримтын үнэтэй бичлэг хийсэн гэдгээ тэр даруй шалгаж болох ба цаашид шаардлагатай үед хувилж авч болно. Дүрс бичлэг нь мэдээлэл хийх ба сурталчилгааны танилцуулгын зорилгоор ашиглахад мөн тохиромжтой байдаг. Ослыг шинжлэн шалгах ажиллагааны үед хийсэн ослын газар, агаарын хөлгийн үлдэгдэл буюу эд ангиуд, лабораторийн туршилт ба шинжилгээ, ярилцлага, Албаны шинжлэн шалгагчийн ажиллагааг тодорхой харуулсан дүрс бичлэгийг арилгаж болохгүй ба ослын материалд оруулах ёстой.

4.23. Дижитал хөдөлгөөнгүй гэрэл зураг нь дүрсний чанарыг тухайн үед нь шалгах ба интернэтээр дамжуулж бусад хүмүүст илгээхэд маш тохиромжтой байдаг. Зөвхөн анхны өөрчлөгдөөгүй дүрсийг ашиглахад анхаарах ёстой. Дүрсийг ямар нэг шалтгаанаар өөрчилсөн бол жишээ нь, тэмдэглэл хийсэн, зургийг танасан, дүрсний чанарыг өөрчилсөн зэрэг үед эдгээр өөрчлөлтүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг зурагтай хамт өгөх ёстой. Дижитал зургийг мөн цахим аргаар тайлан болон бусад бичиг баримтуудад оруулахад хялбар байдаг.

Тав. Агаарын гэрэл зураг авах

5.1. Шинжлэн шалгах ажиллагаа явуулж буй багийн ахлах шинжлэн шалгагч нь шаардлагатай гэж үзвэл шинжлэн шалгах ажиллагааны явцад ослын газар өөрчлөгдөхөөс өмнө агаарын гэрэл зургийг авна. Агаарын гэрэл зургийг авахдаа газар дээрх ач холбогдол бүхий дүрсүүд, анхны цохилтын цэг, газар дээр гарсан галын хэсгүүдийг оруулах ёстой.

5.2. Агаарын хөлгийн осол, зөрчил болсон нутаг дэвсгэрийн зургийг агаараас авч буй тохиолдолд агаарт байх хугацааг дээд зэргээр ашиглахын тулд тухайн этгээд нь гэрэл зурагт тавигдах шаардлагуудын талаар маш

тодорхой ойлголттой байх ёстой ба нислэгийн өмнө нисэгчид сайтар танилцуулах ёстой.

5.3. Ослын газрын нөхцөл байдлын зургийг агаараас авах ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар”-ын 5.8.5 дугаар бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Шөнийн гэрэл зураг

6.1. Ослын байрлал, үлдэгдэл түүний нөхцлийг бүрэн харуулсан фото зургийг нэн даруй авч эхлэх шаардлагатай. Уг ажиллагааг шинжлэн шалгах ажиллагаанд оролцож буй шинжлэн шалгагчид, ахлах шинжлэн шалгагчийн томилсон этгээд хийж гүйцэтгэнэ.

6.2. Хэрэв осол, зөрчил шөнийн цагаар гарсан, байгалийн гэрэлгүй үед тохиолдсон бол ослын талаар системтэй фото зургийн баримт бүрдүүлэхийн тулд хойшлуулалгүйгээр нөхцөл байдлыг дүгнэн шөнийн цагт фото зураг авах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Ослын газрын ерөнхий зургийг аль болох олон удаа авна.

6.3. Сонголт байгаа тохиолдолд шөнийн зураг авахаас зайлсхийх хэрэгтэй. Гэрэлтүүлгийн гэрэл нь зай ихсэх тусам мууддаг учраас ойрын болон дундын зайны зураг авах шаардлагыг дөнгөж хангадаг. Гэрэлтүүлгийн гэрлээр ослын газрын ерөнхий дүрс, холын зайны зураг авалт болон хэт том зүйлийн зургийг авахад хангалтгүй байдаг.

6.4. Хэрвээ шөнө зураг авах зайлшгүй шаардлага гарсан бол Ослын газрын нөхцөл байдлын зургийг авах ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар”-т заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

Долоо. Стерео гэрэл зураг болон Фотограмметр

7.1. Ослын газрын стерео гэрэл зураг нь танд осол болсноос хойш хэдэн сарын дараа хэрэг болж болно. 3-D дүрс буулгагчийг ашигласнаар хүний хэмжээг ялгаж, нарийн төвөгтэй нөхцөлд ослын үлдэгдлийн хэсгүүдийн хоорондох зайг тооцох боломжтой болно. Стерео гэрэл зураг нь маш энгийн байдаг. Хүний 2 нүд нэг зүйлийг 2 өөр өнцгөөс хардаг учраас зайг мэдэрдэг. Нэг нүдтэй хүн харж байгаа зүйл хүртэлхи зайг мэдрэхгүйтэй ижил 1 линзтэй аппарат ч гэсэн зайг мэдэрдэггүй. Нэг гэрэл зураг зайг харуулдаггүй боловч 2 юмуу 3 инчийн зайтай нэг хэвтээ хавтгайд авсан 2 зураг хүний 2 нүдтэй адил зайг мэдэрдэг. Та 2-дахь гэрэл зургийг авахдаа 1-дэх зургийг авсан байдлаас ослын газар ба камер хоорондын 1 хувьтай тэнцэх зайнд шилжүүлж авна.

7.2. Хэрвээ стерео зураг авах зайлшгүй шаардлага гарсан бол уг ажиллагааг Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагааны заавар”-ын 5.8.7 дугаар бүлэгт заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

